

2016 ОНЫ 3 САРЫН БАЙДЛААРХИ ГЭМТ ХЭРЭГ, ЗАХИРГААНЫ ЗӨРЧЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2016.04.07

Улаанбаатар хот

Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн талаархи гомдол мэдээлэл

1.1. Хүлээн авч шалгасан нийт гомдол мэдээлэл:

- Урьд оны үлдэгдэл 3, тухайн оны 168 нийт 171 гомдол мэдээлэл шалгасан: Үүнд эрүүгийн албанаас эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 12, харъяаллын дагуу 1,



Нийт 159 гомдол мэдээлэл шийдвэрлэсэнээс

- 96 буюу 60 хувийг гэмт хэргийн,
- 1 буюу 1 хувийг бусад,
- 1 буюу 1 харъяаллаар шилжүүлж,
- 61 буюу 38 хувийг зөрчлийн талаарх гомдол мэдээлэл эзэлж байна.

1.2. Гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:

- 32 буюу 33 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн,
- 64 буюу 67 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан, тэдгээрээс гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлтэй 63, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 1 байна.

1.3. Гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:

- 54 буюу 56 хувийг 5 хоногт,
- 42 буюу 44 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна.

1.4. Зөрчлийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байдал:

- 59 буюу 97 хувийг шийтгэврээр торгож,
- 2 буюу 3 хувийг зөрчлийг хянан шалгаж шийдвэрлэх боломжгүй үндэслэлээр шийдвэрлэсэн.

1.5. Нийт зөрчлийн талаархи гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа:

- 61 буюу 100 хувийг 14 хоногт шийдвэрлэсэн байна.

1.6 Бусад шийдвэрлэлт:


-1 гомдол, мэдээллийг газар дээр нь зөвлөлгөө өгсөн үндэслэлээр шийдвэрлэсэн байна.

Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг

2.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

- Хэлтсийн хэмжээнд эхний 3 сард 28 гэмт хэрэг бүртгэгдсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1 буюу -3,4 %-аар буурсан байна. Эдгээрээс Завхан аймгийн ЦГ-н 0201613000048.00 дугаартай 100.1-ээр үүссэн хэрэг манай мэдээнд орсон байна.


2.2. Гэмт хэргийн ангилал өсөлт, бууралтаар:




2.3. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн төрлөөр:



2.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн гариг:



2.5. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг:



2.6. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал

- Нийт гэмт хэргийн 8 нь согтуугаар, эмэгтэй хүн оролцсон 7, бүлэглэн гүйцэтгэсэн 3 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

2.7. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар



-Гудамж талбайд 3 хэрэг үйлдэгдсэний 3 нь төмөр зам дээр,

-Олон нийтийн газар 19 үйлдэгдсэний 14 нь төмөр замын вокзал дээр,

-Нийтийн тээвэрт 1 үйлдэгдсэн нь галт тэргэнд тус тус үйлдэгдсэн байна.

Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт


3.1. Гэмт хэргийн илрүүлэлт:

- Гэмт хэргийн илрүүлэлт 73,3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өссөн.

3.2. Илрүүлэлт гэмт хэргийн ангилал, хувиар:



3.3. Бүтгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй гэмт хэрэг:



3.4. Яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн төрөл

-Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх -1,

-Бусдын эд хөрөнгийг хулгайлах-2,

-Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах-1 гэмт хэрэг илрээгүй байна. Дээрхи хэргүүдээс гадна өмнөх онуудын эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 12 хэрэг түдгэлзүүлээстэй байна.


Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогчид

4.1. Гэмт хэрэгт холбогдогчид:


Нийт 26 хүн /өмнөх оны мөн үеэс 8-р буюу 23,5 %-аар буурсан/ гэмт хэрэгт холбогдсоны:

- 8 эмэгтэй буюу 31 хувийг эзэлж байгаа нь урьд оны мөн үеэс 2 буюу -20 хувиар буурсан байна.
- Урьд оны мөн үед 18 хүртэл насны хүүхэд холбогдсон хэрэг 4 гарч байсан бол энэ онд холбогдоогүй байна.

4.2. Гэмт хэрэгт холбогдогчид насны ангиллаар:



4.3. Гэмт хэрэгт холбогдогчдын нийгмийн байдал




Тав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

5.1. Гэмт хэргийн улмаас:

- 26 иргэн хохирсон, /эмэгтэй-15/
- Нас барсан 2
- Гэмтсэн хүн 9 байна

5.2. Гэмт хэрэгт хохирогчид насны ангиллаар:



5.3. Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирол



Мөрдөн байцаалтын шатанд нийт хохиролынхоо 100 % төлүүлсэн бол Хэрэг бүртгэлтийн шатанд 79,8 % нөхөн төлүүлсэн байна. Хэлтсийн нийт хохирол нөхөн төлүүлэлт 86,1 % байна.

5.4 Гэмт хэргийн шийдвэрлэлт

Урьд оны үлдэгдэл 6, тухайн онд шинээр дугаар авсан 33, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 9, нийт 48 хэрэг шалгаснаас 33 хэрэг хэрэгсэхгүй болгох саналтай, 2 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорт шилжүүлж, 1 хэрэг нэгтгэснээс хорогдсон, 5 хэргийг шинээр түдгэлзүүлсэн байна. Одоо 7 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас МБ шатанд-5, ХБ шатанд 2 байна. Хэлтсийн хэмжээнд нийт 12 эрүүгийн түдгэлзүүлээстэй байгаагаас мөрдөн байцаалтын шатанд-9, хэрэг бүртгэлтийн шатанд 3 байна.

Зургаа. Захиргааны зөрчил

6.1. Шалгасан захиргааны зөрчил:

- нийт 4615 захиргааны зөрчил бүртгэгдсэн,
- өмнөх оны мөн үед 4200 байснаас 415 нэгжээр буюу 9,9 хувиар өссөн.
- 4539 иргэнийг 76 сая 450,2 мянган төгрөгөөр торгосны 2517 зөрчил нь /12 сая 585,0 мянган төгрөг/ торгуулийн тасалбараар, 2022 зөрчил нь /63 сая 475,2 мянган төгрөг/ бэлэн бусаар торгожээ.
- Шийтгэврээр 76 хүнийг 2 сая 845,2 мянган төгрөгөөр торгосон байна.
- Торгуулийн хуудсаар 42 гадаадын иргэнийг 210 мянган төгрөгөөр, 1 гадаадын иргэнийг шийтгэврээр 50,0 мянган төгрөгөөр торгосон байна.

6.2. Захиргааны зөрчлийг шийдвэрлэсэн албан тушаалтан:

- Цагдаагийн алба хаагч 76 захиргааны зөрчил шийдвэрлэсэн байна.

6.3. Захиргааны зөрчлийн улмаас учирсан хохирол:

- Нийт 5887,7 мянган төгрөгний хохирол учирснаас 5663,4 мянган төгрөгийн хохирол буюу 96,2 % хувийг төлүүлсэн байна.


6.4. Шийтгэврээр захиргааны шийтгэл ногдуулсан хууль тогтоомж:

- 18 буюу 30 %-ийг ЗХТХ-аар,
- 51 буюу 64 %-ийг ЗХАБТХ-аар,
- 7 буюу 6 %-ийг ТХТХ-аар тус тус шийтгэл ноогдуулсан байна.

6.5. Захиргааны хариуцлагын тухай хуулиар шийтгэврээр арга хэмжээ авсан байдал:

- Танхайрах 4,
- Галт тэрэгний АБ, ашиглалтын журам зөрчих 11,
- ЦАХ-ийн хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх 3

6.6. Захиргааны хариуцлагын тухай хуулиар торгуулийн хуудсаар арга хэмжээ авсан байдал:



6.6. Захиргааны зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо:



-зам дээр үйлдэгдсэн 51 зөрчлийн 47 нь төмөр замын гарам дээр,

-олон нийтийн газар үйлдэгдсэн 4 зөрчил нь төмөр замын буудал дээр ,

-нийтийн тээвэрт үйлдэгдсэн 3 зөрчил нь галт тэргэнд тус тус үйлдэгдсэн байна.

6.7. Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн өдөр:

- 688 нь Даваа гаригт
- 604 нь Мягмар гаригт
- 705 нь Лхагва гаригт

- 691 нь Пүрэв гаригт
- 671 нь Баасан гаригт
- 542 нь Бямба гаригт
- 714 нь Ням гаригт үйлдэгдсэн байна.

6.8. Бүртгэгдсэн захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цаг:

- 06-12 цагт 1831,
- 13-18 цагт 1530,
- 19-24 цагт 1027,
- 01-05 цагт 227 зөрчил тус тус үйлдэгдсэн байна.

6.9. Бүртгэгдсэн захиргааны зөрчил үйлдэгдсдийн онцлог:

- 9 нь согтуугаар ,
- 8 нь эмэгтэй хүн оролцсон ,
- 2 нь хүүхэд оролцсон байна.

6.10. Эрүүлжүүлэх үйл ажиллагаа:

- 673 хүн эрүүлжүүлж 2767,6 мянган төгрөгийн үйлчилгээний хөлс авсан байна.
- 1 хүнийг сайн дурын эмчилгээнд хамруулсан.

6.11. Туслах тоо бүртгэлийн судалгаа:

- Эмзэг цэгийн объектын судалгаанд-3,
 - Архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгжийн судалгаанд-3,
 - Гэмт хэрэгт уруу татагчийн судалгаанд-1,
 - Гэмт хэрэгт холбогдож, өртөж болзошгүй этгээдийн судалгаанд-76,
 - Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүний судалгаанд-1,
 - Архаг архичдын судалгаанд-5 тус шивэгдсэн байна.
- Нийт объектын судалгаанд-6, субъектын судалгаанд-83 баяжилт хийгдсэн байна.

МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН АХМАД Ц.САЙХАНЗОРИГ